

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/306/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@aaudit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.04.20 № 07/342
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 109,691.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн тодотголоор 681,800.0 мянган төгрөгийн төсвийг бууруулсан, тодотгосон төсвөөс 392,903.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна. ТӨБЗГ-ын шийдвэрээр байгууллагын эзэмшилд ашиглагдаж байсан 159,800.0 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,783,814.74	18,840,194.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,783,814.74	18,840,194.00
35400	Хангамжийн материал	57,783,814.74	18,840,194.00
35410	Бичиг хэргийн материал	5,522,066.00	1,798,437.50
35420	Аж ахуйн материал	124,494.00	1,169,109.50
35440	Түлш, шатах тослох материал	1,529,000.00	-
35460	Хүнсний материал	273,366.00	-
35470	Бусад хангамжийн материал	50,334,888.74	15,872,647.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,437,377,529.39	1,963,585,580.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,437,377,529.39	1,963,585,580.90
39200	Биет хөрөнгө	2,055,912,340.03	1,682,013,016.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,296,194,926.88	2,296,194,926.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,264,845,108.44)	(1,303,815,023.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	320,241,467.50	160,441,467.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(233,830,009.25)	(88,967,509.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,156,234,595.00	1,226,411,405.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(274,000,192.55)	(649,130,501.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,755,180.86	83,755,180.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,365,158.75)	(71,995,657.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,636,065.00	59,636,065.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,109,426.22)	(30,517,336.03)
39300	Биет бус хөрөнгө	381,465,189.36	281,572,564.32
39301	Программ хангамж	282,858,000.00	282,858,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(70,827,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	160,434,620.00	160,434,620.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(61,677,430.64)	(90,893,055.68)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,495,161,344.13	1,982,425,774.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	49,596,910.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	49,596,910.00
41300	Өглөг	-	49,596,910.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	49,596,910.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,495,161,344.13	1,932,828,864.90
51	Засгийн газрын хувь оролцоо	2,495,161,344.13	1,932,828,864.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	511,123,914.11	511,123,914.11
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	511,123,914.11	511,123,914.11
51200	Хуримтлагдсан үр дүн	1,087,551,601.46	525,219,122.23
51210	Өмнөх үеийн үр дүн	297,429,856.25	1,087,551,601.46
51220	Тайлант үеийн үр дүн	790,121,745.21	(562,332,479.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	896,485,828.56	896,485,828.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,495,161,344.13	1,982,425,774.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,506,717,000.00	6,092,005,377.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,322,958,000.00	20,579,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,322,958,000.00	20,579,900.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,286,130,000.00	20,579,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	36,828,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,183,759,000.00	6,071,425,477.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,991,095,000.00	5,817,359,637.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,991,095,000.00	5,698,538,697.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	118,820,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	192,664,000.00	254,065,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	169,547,500.00	216,370,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,166,500.00	17,766,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,950,000.00	19,928,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,689,284,384.17	6,517,750,376.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,689,284,384.17	6,517,750,376.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,647,807,058.03	6,359,629,613.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	673,417,434.43	791,884,336.11
210101	Үндсэн цалин	531,982,745.87	521,053,493.37
210102	Нэмэгдэл	107,947,436.56	119,436,855.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,487,252.00	111,112,000.00
210104	Урамшуулал	-	40,281,987.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,852,724.76	101,426,626.66
210201	Тэтгэврийн даатгал	64,680,185.02	69,936,962.18
210202	Тэтгэмжийн даатгал	6,812,994.48	8,261,954.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,277,196.93	6,357,563.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,275,440.58	1,531,578.33
210205	Эрүүл мэндийн даатгал	12,806,907.75	15,338,567.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,626,105.62	51,497,706.05
210301	Гэрэл, цахилгаан	14,824,521.12	14,797,813.70
210302	Түлш, халаалт	25,155,243.50	31,984,742.35
210303	Цэвэр, бохир ус	2,646,341.00	4,715,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	111,758,598.58	226,718,956.94
210401	Бичиг хэрэг	19,603,188.20	24,431,879.50
210402	Тээвэр, шатахуун	22,101,500.00	54,872,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,625,446.38	8,742,227.20
210404	Ном, хэвлэл	29,021,000.00	496,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,407,464.00	81,700,139.98
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	54,696,550.26
2105	Норматив зардал	215,834,376.26	50,543,444.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	214,335,176.26	-
210502	Хоол, хүнс	1,499,200.00	50,543,444.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,830,794.90	8,466,450.00

210604	Урсгал засвар	3,830,794.90	8,466,450.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	16,988,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	16,988,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,109,814,075.43	4,484,086,335.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,105,374,002.43	4,476,915,743.04
210803	Даатгалын үйлчилгээ	534,060.00	3,914,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,113.00	288,213.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,769,900.00	1,997,000.00
210807	Газрын төлбөр	648,000.00	971,249.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,972,948.05	628,017,758.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,436,931.39	84,049,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	373,536,016.66	543,968,758.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,477,326.14	158,120,762.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,540,476.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,540,476.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,477,326.14	154,580,286.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,527,256.14	134,651,886.94
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,950,070.00	19,928,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	817,432,615.83	(425,744,999.23)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,310,870.62	136,587,480.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	27,310,870.62	-
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	136,587,480.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	790,121,745.21	(562,332,479.23)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,183,759,000.00	6,071,425,477.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,183,759,000.00	6,071,425,477.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,991,095,000.00	5,817,359,637.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,991,095,000.00	5,698,538,697.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	118,820,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	192,664,000.00	254,065,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	169,547,500.00	216,370,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,166,500.00	17,766,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,950,000.00	19,928,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,183,759,000.00	5,952,604,537.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,183,759,000.00	5,952,604,537.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,142,281,673.86	5,794,483,774.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,591,975.39	791,884,336.11
210101	Үндсэн цалин	503,529,289.85	526,264,338.37
210102	Нэмэгдэл	140,404,702.45	118,161,951.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,657,983.09	107,176,058.79
210104	Урамшуулал	-	40,281,987.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,844,157.75	101,426,626.66
210201	Тэтгэврийн даатгал	58,920,567.41	69,951,964.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,564,044.48	8,229,638.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,277,196.93	6,351,870.55
210204	Ажилгүйдлийн даатгал	1,275,440.58	1,534,705.58
210205	Эрүүл мэндийн даатгал	12,806,908.35	15,358,448.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,626,105.62	51,497,706.05
210301	Гэрэл, цахилгаан	14,824,521.12	14,797,813.70
210302	Түлш, халаалт	25,155,243.50	31,984,742.35
210303	Цэвэр, бохир ус	2,646,341.00	4,715,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,947,200.00	47,518,587.20
210401	Бичиг хэрэг	4,876,400.00	7,141,460.00
210402	Тээвэр, шатахуун	3,946,500.00	10,412,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,650,100.00	8,764,227.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,474,200.00	19,440,900.00
2105	Норматив зардал	2,999,930.00	26,789,000.00
210502	Хоол, хүнс	2,999,930.00	25,780,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,008,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,338,944.90	40,878,240.00
210602	Тавилга	-	17,766,540.00
210604	Урсгал засвар	1,338,944.90	23,111,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	22,680,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	22,680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,272,699,901.81	4,618,879,068.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,268,039,828.81	4,611,708,476.04

210803	Даатгалын үйлчилгээ	534,060.00	3,914,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,113.00	288,213.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,989,900.00	1,997,000.00
210807	Газрын төлбөр	648,000.00	971,249.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,533,458.39	92,930,210.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,533,458.39	92,930,210.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,477,326.14	158,120,762.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,540,476.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,540,476.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,477,326.14	154,580,286.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,527,256.14	134,651,886.94
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,950,070.00	19,928,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	118,820,940.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	118,820,940.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	118,820,940.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	118,820,940.00
221001	Их засвар	-	118,820,940.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(118,820,940.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	297,429,856.25	1,705,039,598.92
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	297,429,856.25	1,705,039,598.92
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	790,121,745.21	790,121,745.21
10	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	1,087,551,601.46	2,495,161,344.13
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	1,087,551,601.46	2,495,161,344.13
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
16	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
17	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
18	Тайлант үеийн үр дүн	-	-	(562,332,479.23)	(562,332,479.23)
19	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	525,219,122.23	1,932,828,864.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,956,790,800.00	5,563,886,810.06	392,903,989.94	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,956,790,800.00	5,563,886,810.06	392,903,989.94	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,953,249,100.00	5,560,346,334.06	392,902,765.94	93.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	816,930,500.00	791,884,336.11	25,046,163.89	96.9
210101	Үндсэн цалин	559,488,100.00	526,264,338.37	33,223,761.63	94.1
210102	Нэмэгдэл	139,614,400.00	118,161,951.95	21,452,448.05	84.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	117,828,000.00	107,176,058.79	10,651,941.21	91.0
210104	Урамшуулал	-	40,281,987.00	(40,281,987.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,542,700.00	101,426,626.66	1,116,073.34	98.9
210201	Тэтгэврийн даатгал	69,680,800.00	69,951,964.35	(271,164.35)	100.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,215,500.00	8,229,638.12	(14,138.12)	100.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,572,300.00	6,351,870.55	220,429.45	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,643,100.00	1,534,705.58	108,394.42	93.4
210205	Эрүүл мэндийн даатгал	16,431,000.00	15,358,448.06	1,072,551.94	93.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,485,700.00	51,497,706.05	987,993.95	98.1
210301	Гэрэл, цахилгаан	16,228,000.00	14,797,813.70	1,430,186.30	91.2
210302	Түлш, халаалт	30,977,100.00	31,984,742.35	(1,007,642.35)	103.3
210303	Цэвэр, бохир ус	5,280,600.00	4,715,150.00	565,450.00	89.3
2104	Хангамж, бараа материалын зардал	31,504,800.00	29,517,787.20	1,987,012.80	93.7
210401	Бичиг хэрэг	7,256,500.00	6,581,460.00	675,040.00	90.7
210402	Тээвэр, шатахуун	1,667,500.00	1,400,000.00	267,500.00	84.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,806,900.00	8,764,227.20	1,042,672.80	89.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,760,000.00	1,760,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,013,900.00	11,012,100.00	1,800.00	100.0
2105	Норматив зардал	1,008,500.00	1,008,500.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,008,500.00	1,008,500.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,111,700.00	23,111,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	23,111,700.00	23,111,700.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,177,200.00	6,810,000.00	367,200.00	94.9
210702	Дотоод албан томилолт	7,177,200.00	6,810,000.00	367,200.00	94.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,876,469,000.00	4,519,683,068.04	356,785,931.96	92.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,864,467,500.00	4,512,512,476.04	351,955,023.96	92.8
210803	Даатгалын үйлчилгээ	7,812,700.00	3,914,130.00	3,898,570.00	50.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	754,800.00	288,213.00	466,587.00	38.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	89,400.00	-	89,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,997,000.00	3,000.00	99.9
210807	Газрын төлбөр	1,344,600.00	971,249.00	373,351.00	72.2

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,019,000.00	35,406,610.00	6,612,390.00	84.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,019,000.00	35,406,610.00	6,612,390.00	84.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,541,700.00	3,540,476.00	1,224.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,541,700.00	3,540,476.00	1,224.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,541,700.00	3,540,476.00	1,224.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,956,790,800.00	5,563,886,810.06	392,903,989.94	93.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,956,790,800.00	5,563,886,810.06	392,903,989.94	93.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,956,790,800.00	5,563,886,810.06	392,903,989.94	93.4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	99	99		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	49	49		
620001	Удирдах ажилтан	2	2		
620002	Гүйцэтгэх ажилтан	47	47		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49	49		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	49	49		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	254,065,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,065,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,137,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,000,800.00
210401	Бичиг хэрэг	560,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,012,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,428,800.00
2105	Норматив зардал	25,780,500.00
210502	Хоол, хүнс	25,780,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,766,540.00
210602	Тавилга	17,766,540.00
2107	Томилолт, зочны зардал	15,870,000.00
210702	Дотоод албан томилолт	15,870,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,196,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,196,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,523,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,523,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,928,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,928,400.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	19,928,400.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,065,840.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	254,065,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	216,370,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,766,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,928,400.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 109,691.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 29,592.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 80,099.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 49,596.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	49,596.9					1	49,596.9
Бусад хангамжийн материалын дансанд 8,585.5 мянган төгрөгийн хүнсний материалыг данс буруу ангилж бүртгэсэн байна.	1	8,585.5					1	8,585.5
Худалдан авалтын гүйлгээг цахим төлбөрийн системтэй тулган шалгахад 24,311.0 мянган төгрөгөөр илүү, 21,917.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	1	21,917.0					1	21,917.0
Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдсон 17,552.00 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	17,552.0			1	17,552.0		
Тайлант онд Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Сэтгүүлчийн ур чадварыг дэмжих", "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал" сургалтуудыг танхимаар зохион байгуулж 12,040.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	12,040.0			1	12,040.0		
Дүн	5	109,691.4			2	29,592.0	3	80,099.4

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд нийт 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 150 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1				1	
Дүн	1				1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй даргын туслах, тооцооны нягтлан бодогч, касс, эд аж ахуйн нярав, жолооч, үйлчлэгч зэрэг орон тоонд 7 хүнийг гэрээгээр ажиллуулж 64,000.0 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргасан байна.	1				1	64,000.0
Дүн	1				1	64,000.0
Нийт дүн	2				2	64,000.0